

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМЫН
ХҮРЭЭНД БОЛОВСРУУЛАН ИЛГЭЭВ.**

**НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
36 дахь хуралдаан**

2020 оны 5 дугаар сар

МОНГОЛ УЛС

БҮЛГИЙН ЭРХИЙН ТАНИЛЦУУЛГА

Танилцуулга бэлтгэсэн:

Хүүхдийн эрх: Хүүхдийн Эрхийн Форум (Хүүхэд хамгааллын сүлжээ, хүүхдийн оролцооны сүлжээний байгууллагууд хамтарсан)

Эмэгтэйчүүдийн эрх: Бүсгүйчүүд XXI зуун, Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан, Иргэдэд туслах хүний эрхийн төв, Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо, Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо, Хууль судлал хүний эрх төв

Ахмадын эрх: Митчел Сан, Ирээдүйн гарц ТББ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх: Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Нэгдсэн Холбоо, Түгээмэл эрх ТББ

Холбогдох хаяг:

Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо
И-мэйл хаяг: mwesf1@gmail.com, утасны дугаар: 70137083

ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-ДЫН ФОРУМ (ХЭФ)

1. Монголын Хүний Эрхийн ТББ-дын Форум (ХЭФ) нь 2010 онд ЮПР буюу НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт ТББ-дын бэлтгэх сургалтын үеэр байгуулагдсан юм. Түүнээс хойш ХЭФ нь 50 гаруй ТББ-ыг эгнээндээ нэгтгэн, Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг сурталчлах, хамгаалах чиглэлээр тууштай ажиллаж ирлээ. ХЭФ нь ЮПР-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төр болон төрийн бус байгууллагуудын дунд зөвлөлдөх уулзалтууд болон, шаадлага, асуулга явуулах, жагсаал цуглаан зохион байгуулах замаар нөлөөллийн үйл ажиллагаа хийж байна.
2. Энэ удаагийн Бүлгийн эрхийн тайлан илтгэлийг ХЭФ-ын гишүүн байгууллагуудаар хэлэлцэн сэдвийг тогтож, төрийн 9 байгууллагаас илтгэлд холбогдох асуудлаар мэдээлэл авахын зэрэгцээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харъяа агентлагуудтай хоёр удаа зөвшилцөх, ойлголтоо нэгтгэх уулзалт хийв. Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум (ХЭФ)-ын хурлаар хоёр удаа хэлэлцүүлэхийн зэрэгцээ үндэсний зөвлөлдөх уулзалтаар илтгэлийн төслийг танилцуулж, талуудын саналыг тусгалаа. ТББ-дын зүгээс бэлтгэсэн илтгэлийн эхний төслийг 11 аймаг, 4 дүүрэгт төр болон төрийн бус байгууллагын нийт 300 гаруй төлөөлөлд танилцуулж, санал шүүмжийг авсан.

НЭГ. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ

3. Монгол Улс UPR II циклээс хүүхдийн эрхийг хангахтай холбоотой зөвлөмжүүдийг амжилттай хэрэгжүүлэхийг зорьж байна. Хүүхдийн эрхийг хамгаалахаар сүүлийн 3 жилд шинээр бий болсон эрх зүйн дагуу нийгмийн бүх орчинд хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад оролцогч бүх талуудыг төрөөс удирдах, дэмжих, хянах, зохицуулах үүргийг сайжруулах хэрэгцээ өсч байна. Учир нь байгууллага, хуулийн этгээд бүр хүүхдийн эрхийг хүндэтгэх зарчмыг хэрэгжүүлж, хүүхдээ асрах эцэг эхийн чадварыг дэмжих зорилгоор хамт олны дунд эцэг эхийн зөвлөл байгуулах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх боломж, арга замыг эрэлхийлж эхэлж байна. Мөн хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих улсын байцаагчид, хүүхэд, өсвөр үеийхний оролцоо, үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах түвшинд санал хүсэлтээ гаргах, шийдвэрлүүлэх боломжийг дэмжих сайн дурын үүрэгтэй, хүүхдийн хамт олноос сонгогдсон “Хүүхдийн элч” зэрэг шинэ, шинэ механизмыг ажиллах нөхцөлөөр хангах, хүүхдийн эрхийг бодитой хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд төрийн байгууллагуудын

хооронд төдийгүй, бизнесийн салбар, хуулийн этгээдүүд, иргэд, олон нийтийн үүсгэл санаачилга, оролцоог дэмжих уян хатан зохицуулалтыг хангах асуудал өдөр тутам тулгарч байна.

4. Монгол Улсад үндэсний түвшинд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайд түүний хариуцсан төрийн захиргааны төв байгууллага ХНХЯ хүүхдийн эрхийг хамгаалах үйлст манлайлах үүрэгтэй.¹ Энэ Сайд болон түүний эрхэлсэн яамны харъяанд Засгийн газрын хэрэгжүүлэгч статус бүхий Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хэмээх 54 хүний орон тоотой агентлаг ажилладаг. Мөн Ерөнхий Сайд тэргүүлдэг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл бий. Уг зөвлөлд яамдын төрийн нарийн бичгийн дарга нар голлон бусад талуудын өргөн төлөөлөл орж бүрдүүлэн зөвлөлдөх хэлбэрээр ажилладаг. Энэ зөвлөлийн Ажлын албаны үүргийг дээрх агентлаг буюу ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар гүйцэтгэдэг. Гэвч дээрх зөвлөлийн жилийн хугацаанд ганц нэгхэн болох хурал түүнээс гарах шийдвэр нь салбар дундын зохицуулалтын асуудлаас хөндий байна. ХНХЯ энэ зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин дэргэдээ Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021он) ийн зохицуулалтыг хангах зорилгоор салбар дундын байнгын Ажлын хэсэг ажиллуулж байна.
5. Хүүхдийн эрхийг хангах бодлого, үйл ажиллагааны салбар дундын үндэсний зохицуулалтыг хангах эрх зүйн үүрэгтэй эдгээр субъектуудээс энэ чиглэлээр бодлого, чиглэл, удирдамж, арга аргачлал гарахгүй, аль ч салбарт хүүхдийн эрхэд тавих хяналт, мониторинг, мэргэжил арга зүйн зөвлөгөө, нөлөөлөл сул байна. Учир нь дээрх механизмуудын үйл ажиллагаа нь нэр хэмээх төлөвлөгөө, нөлөө бага хурал, эрх зүйн чадамж сул зөвлөмж гаргасан төдий байгаа нь харамсалтай. Хүүхдийн эрхэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний нөлөөг хянах, магадлах, бууруулах, таслан зогсоох, эерэг нөлөө боломжийг дэмжих зэрэг бодлогын хэрэгжилтийг хангахад хөдөө аж ахуй, барилга, худалдаа, үйлчилгээ, уул уурхай зэрэг нийт салбар, байгууллагыг мэдээлэл, зөвлөгөө төдийгүй төрийн байгууллагуудыг удирдлага, хяналт, арга зүйгээр хангах шаардлага өссөөр байна. Товчдоо хүүхдийн эрхийг хангахад салбар дундын асуудлаарх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Жишээ нь хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үндсэн үүрэг бүхий дараахь хоёр төрлийн механизмын үйл ажиллагаанд салбар дундын босоо (шууд удирдлагатай байгууллага, албан тушаалтанд хамаарах) болон хэвтээ (орон нутаг, нэгжийн түвшинд хамаарах)чиглэлийн зохицуулалт байхгүй байна.
6. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээний хүрээнд:
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь эрүүл мэнд, боловсрол, халамж, цагдаа, прокурор, өмгөөлөгч, шүүхийн зөвлөл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төлөөлөл хамтран бүрдүүлж, ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн дарга ахалдаг. Үйлчилгээ, үйл ажиллагааг нь ГБХЗХ-ийн байгууллагууд хариуцна. Хороо хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны явцад болон түүний дараах үе шатанд гэрч, хохирогч, сэжигтэн зэрэг хүүхдэд зохих үйлчилгээ үзүүлж, хянах үүрэгтэй. ХЗДХ ийн ХНХС-ын хамтарсан 2017 оны 3 сарын 27 ны өдрийн 51/69 дүгээр тушаалд цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр зэрэг байгууллагууд зохих мэдээллээ Хороонд төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Гэвч Эрүүгийн хуулийн дагуу цагдаагийн алба хаагч гэмт хэргийн нууцлалыг хангах үүднээс хэргийн талаар мэдээлж болохгүй тул цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн хохирогч, гэрч, сэжигтэн хүүхдийг мэдээлэл Хууль зүйн хороонд ирэхгүй, төвлөрөхгүй байгаа учир хүүхдэд чиглэх зохих үйлчилгээний нөхцөл бүрдэхгүй байна. Энэ нь хянан шийдвэрлэх ажиллагааны хүүхдэд ээлтэй жишиг стандартыг хангах, хянах, процесст оролцогч хүүхдэд шаардлагатай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг гацааж байна. Жишээ нь Хэрэг хянан шийдвэрлэх процесст оролцогчид хууль зүйн хорооны үйлчилгээний талаар өөрсдөө мэдэхгүй байх, хүүхдэд уг үйлчилгээг санал болгох, зөвлөх дэмжлэг алга. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж буй өсвөр насны хүн Хууль зүйн хорооны талаар мэдээлэлгүй, түүнчлэн энэ байгууллагаас суллагдсан хүний талаарх ШШГЕГ-ын мэдээлэл аймаг, дүүрэг, хорооны түвшинд очдоггүйгээс тухайн хүн эргэн нийгэмших, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна.ⁱⁱ

7. Хамтарсан багийн үйлчилгээний хүрээнд: Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж болох сум, дүүрэг, баг, хороонд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу ажиллаж байгаа 609 ⁱⁱⁱ Хамтарсан баг¹ийг Засаг даргын удирдлага дор төрийн гол байгууллагын төлөөлөл бүрдүүлнэ. Энэ багуудын 90 гаруй хувьд сүүлийн 2 жилд үйл ажиллагааны батлагдсан төсөвгүй ажиллаж, ихэвчлэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалахад анхаарал төвлөрүүлдөг. Тухайн орон нутагт гол мэргэжилтнүүдийг төвлөрүүлсний хувьд Хамтарсан баг нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар орчин, хэлбэр үл харгалзаж ажиллах шаардлага байна. Гэвч энэ талаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зэрэг зүйлийн хоорондын нийцэл сул байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг голлон тодорхойлж буй хууль зүйн хороо, хамтарсан багийн хүүхдэд үзүүлэх тус тусын үйлчилгээндээ тэдгээрийн уялдааг хангах, харилцан шилжүүлэх, эргэх холбоотой, тасралтгүй байх нөхцөлийг зохицуулсан дүрэм журамгүйгээс үйлчилгээний чанар, тасралтгүй байдал, уялдаа хангагдаж чадахгүй байна. Мөн эрүүгийн, зөрчлийн хэрэг хянан, шалган шийдвэрлэх процессын хуулиудад

¹ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар Хамтарсан баг нь өрхийн эмч, сүргүүлийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн мэргэжилтнүүд бөгөөд гишүүн тус бүр нь мөн хуульд заасан чиг үүрэг хэрэгжүүлдэг болно.

хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой зохицуулалт тусаагүй байна. Субъектүүдэд төлөөлөлтэй салбар, байгууллагууд хүүхэд хамгааллын үйлчилгээнд нөлөөтэй удирдлагын дэмжлэг сул байна. Жишээ нь Хорооны бүрэлдэхүүнд ажиллаж буй цагдаагийн, прокурорын зэрэг төлөөллийн оролцоо, үүрэг, мэдээллийг үндэслэн “босоо” (төвөөсөө нэгдмэл удирдлагатай бөгөөд орон нутгаас хамаарал бага) удирдлагатай байгууллагуудын нийт бүрэлдэхүүнд хандсан удирдамж чиглэл шаардагддаг.

8. Зөвлөмж

- Хүүхдийн эрхийг хангах, салбар дундын зохицуулалтыг дэмжих эрх зүйн орчныг салбаруудын оролцоотой үнэлж, зохих хууль тогтоомжийг шинэчлэх, ингэхдээ хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагааны Засгийн газрын гол институциудын мэдээллийн удирдлагад тулгуурласан салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрх хэмжээг өргөжүүлэх;
- Эрүүгийн болон Зөрчлийн хэргийг шийдвэрлэх процессын үед хүүхэд, өсвөр насны хүнд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний боломжийг шаардлагатай хууль тогтоомжид нэмж тусгах.
- Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуульд хүүхдэд хамгааллын тухай хуульд нийтлэг зарчмын дагуу мониторинг хийж, салбар дундын зохицуулалтыг сайржуулах шаардлагатай өөрчлөлтийг тусгах.


Хоёр. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ, ЭДИЙН ЗАСГИЙН ТЭГШ БОЛОМЖ, УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО

9. “Хүний эрхэд суурилсан хөгжлийн чиг хандлагыг баримтлах...”^{iv} зарчим бүхий Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого, “...зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулах...” чиглэл бүхий хөдөлмөр эрхлэлтийн бодлого^v, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр^{vi} болон салбарын жендэрийн бодлогыг баталж эхэлсэн, Жендэрийн үндэсний хороог хуулийн дагуу Ерөнхий сайдын дэргэд ажиллуулж статусыг дээрдүүлсэн зэрэг ахиц дэвшил гарсныг онцолж байна. Гэвч өмнөх хэлэлцүүлгээс өгсөн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, эмзэг бүлгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, эмэгтэйчүүдийн улс төрийн эрх тэгш оролцоог хангах чиглэлээр өгсөн зөвлөмж үр дүнтэй хэрэгжсэнгүй.^{vii}
10. **Хөдөлмөрлөх эрхийн зөрчил өргөн хүрээнд байна.** Ажлын байрны бэлгийн дарамт (АББД)-д өртсөн хохирогчдын 98%, ажлын байрны дарамтад өртсөн хохирогчдын 79% эмэгтэйчүүд байна^{viii}. АББД-ын тархалт нэмэгдэж, бизнесийн байгууллагад 20%-50%, эрүүл мэндийн байгууллагад 20%-40% өссөн.^{ix} Мөн ижил үнэлгээтэй ажилд ижил цалин хөлс авах зарчим хэрэгжихгүй, цалингийн дунджийн ялгаатай байдал санхүүгээс бусад салбарт нэмэгдэж байна. Тухайлбал, сүүлийн 3 жилийн дүнгээр эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн цалингийн 2016 онд 88.74%, 2017 онд 83.57%, 2018 онд 82%-д хүрч буурсан.^x Хөдөлмөрийн хуульд заасан ажлын цагийг баримтлахгүй, илүү цагаар

ажиллуулах нь төрийн байгууллагад түгээмэл байгааг 11 аймаг, 4 дүүрэгт төр, төрийн бус байгууллагын 300 гаруй төлөөлөлтэй хийсэн “Хүний эрхийн төлөв байдал орон нутагт” хэлэлцүүлгийн үеэр онцолсон. Хэдийгээр “Төрийн албаны тухай” хуулийг шинэчлэн баталж, илүү цагийн ажлын хөлс олгохоор тусгасан ч илүү цагийн дээд хязгаарыг тогтоогоогүй, төрийн үйлчилгээ тэр дундаа цагдаа, сувилагчийн орон тоо хүрэлцэхгүй байгаа энэ үед илүү цагаар ажиллах явдал буурахааргүй байна.

11. **Хөдөлмөрлөх эрхийг хангах бодлого жендэрт суурьлаагүй.** Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт баримтлах жендэрийн бодлого^{xi} баталсан ч хэрэгжүүлээгүй, салбарын мэргэжилтнүүд жендэрийн мэдрэмж сул, бодлогоо хэрэгжүүлэх арга зам тодорхойгүй байна. Эмэгтэйчүүд бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настныг асарч үйлчилдэг гэсэн шалтгаанаар эдийн засгийн идэвхгүй болж, хөдөлмөр эрхлэх боломж хумигдаж, ажил орлогогүй болох нь нэмэгдэж байна. Үүний улмаас эмэгтэйчүүд өөрийн орлогогүй, санхүүгийн эрх мэдэлгүй болж, улмаар гэр бүлийн, эдийн засгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байна.

График 1,2,3: Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар, хүйсээр^{xii}



12. Хүүхэд асрах үйлчилгээ хүрэлцээгүй байгаагаас эмэгтэйчүүд хүүхдээ сургуульд орох хүртэл, түүнээс ч цааш өөрсдөө асрах сонголт хийхээс өөр аргагүй болж, ажлаасаа урт хугацаагаар завсардах байдал түгээмэл байна.^{xiii} Цэцэрлэгийн хүртээмж муугаас 2-5 насны 250 мянга^{xiv} орчим хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй, гэртээ хүмүүжиж байна. Дунджаар 2200 орчим цэцэрлэг шаардлагатай ч 1435 цэцэрлэг ажиллаж^{xv} байгаа бөгөөд цэцэрлэг барих талаар төлөвлөөгүй байна. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 2030 он хүртэл үргэлжилж байгаа “хүн амын цонх”-ыг харгалзаж үзээгүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүргийг тооцоолоогүй. Мөн бага насны хүүхэдтэй ээжүүдэд зориулсан “Цалинтай ээж” хөтөлбөр нь охид эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог дэмжихийн оронд ажил хийлгүй гэртээ суухыг дэмжсэн гэхээр байна. Энэ хөтөлбөр хүн амаа өсгөх^{xvi} бодлогын хүрээнд гарсан бөгөөд ээжид сард 50,000 төгрөгийн (19usd) тэтгэмж олгох юм. Энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даруй 6 дахин бага хөлс бөгөөд зарим хугацаанд цагийн ажил зэрэг хөлстэй хөдөлмөр хийвэл энэ тэтгэмжийг олгодоггүй. Хүн амаа өсгөх энэ мэт бодлого эмэгтэйчүүдэд ээлтэй биш байна.

13. **Эмэгтэйчүүд эдийн засгийн боломжоос тэгш хүртэж чадахгүй байна.** Үндэсний статистикийн хорооноос гаргасан хамгийн өндөр болон хамгийн бага цалин хөлстэй тус бүр 5 салбарын ажилчдыг хүйсээр авч үзэхэд ашиг орлоготой салбарт эрэгтэйчүүд 70% орчим оролцоотой байхад хамгийн бага цалин хөлстэй салбарт эмэгтэйчүүд 70% орчмыг эзэлж байна.^{xvii}

14. **Охид, эмэгтэйчүүд тэр дундаа малчин эмэгтэйчүүд хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлж, хамгийн бага үнэлгээтэй эсхүл үнэлгээгүй хөдөлмөрт цаг заваа зарцуулж байна.**

Монгол Улсын цаг ашиглалтын судалгаагаар 2011 онд хөлсгүй ажилд эмэгтэйчүүд 4.8 цаг, эрэгтэйчүүд 2,3 цаг зарцуулж байсан бол 2015 онд эрэгтэйчүүд 1,6 цаг болж буурсан байхад эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг 4.3 байгаа нь бараг ахиц гараагүйг харуулж байна.^{xviii} Хөдөө орон нутаг, алслагдмал газарт хүнд хөдөлмөр эрхэлж, албан бус салбарт ажиллаж байгаа иргэдийн хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн талаар судалгаа хомс байна. Хувиараа, худалдаа наймаа хийдэг 100 эмэгтэйн дунд хийсэн судалгаагаар 31.5% нь хөдөлмөрийн гэрээгүй, 31.4% нь ажилд орохдоо бичиг баримт, хөрөнгийн барьцаа өгсөн^{xix} гэж хариулсан нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тодорхойлсон албадан хөдөлмөрийн хэлбэр байгааг харуулж байна.^{xx}

15. **Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонгох, сонгогдох тэгш эрх хангагдахгүй байна.**^{xxi} Сүүлийн 3 удаагийн УИХ-ын сонгуулийн статистикийг харвал нийт нэр дэвшигчид эзлэх эмэгтэйчүүдийн хувь өсөж, буурсан буюу 2008 онд 18.5%, 2012 онд 32%, 2016 онд 26% байгаа нь эмэгтэйчүүдэд улс төрийн тэгш боломж олгох түүштай бодлого байхгүйг илэрхийлж байна. Монгол Улс “Мянганы хөгжлийн зорилт”-оор хүлээсэн улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх амлалтаа биелүүлээгүй. Түүгээр ч үл барам зорилтоо хэрэгжүүлэх алхмаасаа удаа дараа ухарсан. Сүүлийн жишээ гэхэд Сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчдийн 30%-ийг аль нэг хүйсийн төлөөлөл байх заалтыг сонгууль болохоос сар хүрэхгүй хугацааны өмнө 20% болгож бууруулсан явдал юм.^{xxii} Энэ нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар тогтоосон түвшинд^{xxiii} ч хүрэхгүй байхад хариуцлага тооцох боломжгүй байгаа нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх улс төрийн хүсэл эрмэлзлэлгүй байгааг нотолж байна. Үүний зэрэгцээ улс төрийн намын төлөвшил сул,^{xxiv} дотоод ардчилалгүй байдал нь эмэгтэйчүүдийг ялгаварлах, улс төрийн өрсөлдөөнд оруулахгүй байх хандлагад хүчтэй нөлөөлж байна. Оруулсан ч намууд эмэгтэйчүүдийг өөр хооронд нь өрсөлдүүлэхээр нэг тойрогт тулгах, ялах магадлал багатай тойргууд дээр эмэгтэй нэр дэвшигчдийг дэвшүүлдэг практик тогтсон. Мөн **улс төрийн санхүүжилтийн^{xxv} ил тод, шударга байдал хангалтгүй байгаа нь улс төрд жендерийн тэгш эрхийг хангахад томоохон хүндрэл учруулж байна.** Улс төрийн намуудын санхүүгийн тайлан, намд өгөх мөнгөн хандив, сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, түүний зарцуулалтад гишүүд сонгогчид нь хяналт тавих боломжгүй. Улс төрийн намууд нэр дэвшигчээс намдаа өргөх босго мөнгөний дүн тогтоодог нь ялгавартай байдлыг бий болгох үндсэн нөхцөл болж байна. Үүний улмаас эмэгтэйчүүдийн санхүүгийн байдал тэдний мэдлэг боловсрол, үр чадвараас илүү чухалд тооцогдоход хүрч байна. Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт босгох арга зам хуулиар нарийвчлан зохицуулагдаагүй, зардлыг хязгаарлах заалт сул байгаа нь хөрөнгөтэй нэр дэвшигчид илүү боломж олгож байна. Үүний дүнд эрэгтэйчүүд давамгайлсан парламент бий болж, бизнес эрхэлдэг гишүүд олонхийг бүрдүүлж байна.

16. **Зөвлөмж:**

- Хөдөлмөрийн тухай хуулийг хөдөлмөрлөх эрхийг дордуулахгүйгээр, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг хориглож, хариуцлагыг холбогдох хуульд оруулж яаралтай батлах, батлагдсан хуулийг олон нийтэд сурталчлан таниулах
- Албан бус салбарт ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг судалж, баталгаажуулах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх

- Нийт төрийн албан хаагч, тэр дундаа хөдөлмөр, нийгмийн хамгаалал, төсөв санхүүгийн салбарын ажиллагсдын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр чадавхжуулах
- Эмэгтэйчүүдийн эдийн засгийн идэвхийг сэргээх, хөдөлмөрлөх эрхийг хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин бүрдүүлэхэд тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Ажлын байрны бэлгийн дарамтыг буцааж гэмт хэрэгт тооцох, гомдол шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх
- Зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин бүрдүүлэхэд эрэгтэй, эмэгтэй болон бага насны хүүхэдтэй аав, ээжүүдийн ялгаатай хэрэгцээг хангахуйц бодлого, үйл ажиллагаа явуулах
- Улс төрийн шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангаагүй улс төрийн намын сонгуульд оролцох эрхийг хязгаарлах хариуцлагыг хуульд тусгах
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хариуцлагыг тус хуулинд болон улс төрийн намын тухай, сонгуулийн тухай хуулиудад тус тус тодорхой тусгах, зөрчсөн тохиолдолд тухайн улс төрийн намыг сонгуульд өрсөлдүүлэхгүй хүртэл арга хэмжээ авах
- Олон улсын жишгийг дагаж квотыг 50%-д хүргэх, нэрсийн жагсаалтыг эрэгтэй, эмэгтэй зип дарааллаар байрлуулах

Гурав. АХМАД НАСТНЫ ЭРХ

17. Монгол Улс өмнөх хэлэлцүүлгээс ахмад настны эрхтэй холбоотой 4 зөвлөмж хүлээж авсан бөгөөд Турк улсаас өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлж, ОХУ, Румын, Венесуэл улсуудаас ирүүлсэн зөвлөмжүүд хэрэгжих шатандаа байна гэж үзлээ.^{xxvi}
18. Монгол Улсын их хурал 2005 онд баталсан “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”-ийг шинэчлэн найруулж ахмад настны эрх, хөгжил, эрүүл мэнд, нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлсэн “Ахмад настны тухай хууль”-ийг 2017 онд УИХ-аар батлаад байна.^{xxvii} Тус хуулийг хүний эрхэд нийцсэн байдлаар эрс шинэчилсэн нь сайшаалтай.
19. Монгол Улсад мөрдөж буй нийгмийн даатгал, халамжийн хуулиар ахмадууд тэтгэвэрт бүрэн хамрагдаж, тэтгэврийн хүртээмжтэй байдлаараа Япон зэрэг хөгжингүй улс, оронтой дүйцэж байна.^{xxviii} Мөн нийт ахмадуудын 78 хувь нь нийгмийн халамжийн нэмэлт хөтөлбөрүүд болох асаргааны тэтгэмж, эмийн үнийн хөнгөлөлт, үнэ төлбөргүй протез, ортопедийн хэрэгсэл, амралт, сувиллын газарт амрах эрхийн бичиг, орон сууцны хөлсний хөнгөлөлт, нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих хөнгөлөлтийг эдэлсэн байна.
20. Гэвч тэтгэвэр нь амьжиргаанд хүрэлцдэггүй, өөр цаг хугацаанд адил хөдөлмөр эрхэлж байсан хүмүүсийн тэтгэврийн зөрүү их байгаа зэрэг нь тулгамдсан асуудал юм. Тухайлбал, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан ахмадуудын дундаж тэтгэвэр 322,671 (121 ам.доллар) байгаа бол 1995 оноос хойш тэтгэвэрт гарсан ахмадуудын дундаж тэтгэвэр 716,123 (268 ам.доллар) төгрөг байна.^{xxix} Энэ нь амьдралын тодорхой хугацааг социалист нийгэмд өнгөрүүлсэн ахмад настнуудын эрх ашиг хохирч байгаагийн тодорхой жишээ

юм. Одоо үйлчилж буй бодлогоор төрийн алба, тэр дундаа боловсрол, хууль сахиулах зэрэг салбарт ажиллаад тэтгэвэрт гарч буй ахмадууд 5 хүртэлх жилийн дундаж цалинтай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж авах зэрэг нэмэлт хамгаалалт байгаа бол 1995 оноос өмнө эсхүл бүтцийн өөрчлөлтөөр тэтгэвэрт гарсан ахмадуудад чиглэсэн ийм бодлого, хөтөлбөр байгаагүй. 2019 оны 7-р сарын байдлаар 310000 (116 ам.доллар) хүртэлх тэтгэвэр авч буй ахмадууд 127,099 буюу нийт ахмадуудын 44.9 хувь, 310001-600000 (116-225 ам.доллар) төгрөгний тэтгэвэр авдаг 130,545 ахмад буюу нийт ахмадуудын 46.1 хувь, 600001- 1920000 (225-720 ам.доллар) хүртэл тэтгэвэр авч буй 25,670 ахмад буюу нийт тэтгэвэр авагчдын дөнгөж 9 хувь байна. Ахмад настнуудын 91 хувь бага тэтгэвэртэй байгаа нь тэдний амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

21. Тэтгэвэр, тэтгэмж 2005 оноос хойш 8.2 хувиар нэмэгдсэн ч тэдний амьжиргаанд хүрэлцэхгүй хэвээр байна.^{xxx} Тэтгэвэрт гарсан эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд илүү эмзэг байдаг. Учир нь тэдний хөдөлмөр эрхлэх хугацаа харьцангуй бага, ихэвчлэн бага цалин авдаг, эрэгтэйчүүдээс урт насалдаг, насныхаа эцэст ганц бие өрх тэргүүлэн үлдэх байдал их зэрэг нь тэдний эмзэг байдалд нөлөөлдөг байна.^{xxxi} Олон жилийн турш тэтгэврийн даатгалд даатгуулаад үр шимийг нь хүртэлгүй нас барсан тохиолдолд гэр бүлийн гишүүн нь тэтгэврийн тодорхой хувийг өгүүлэх зорилготой Хамтын тэтгэврийн тухай хууль УИХ-аас 2015 онд баталсан ч жилийн дараа тус хуулийг хүчингүй болгосон нь энэ чиглэлээр ухралт болсон.^{xxxii}

ЗӨВЛӨМЖ

- 1 Өөр цаг хугацаанд адил хөдөлмөр эрхэлж байсан ахмад настны тэтгэврийн зөрүүг арилгах замаар тэгш бус байдалд өртөж хохирсон бүлгүүдийн эрхийг сэргээх;
- 2 Хамтын тэтгэврийн тухай хуулийг шинээр батлах;
- 3 Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, сайжруулах;
- 4 Ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр амжилттай хэрэгжиж байгаа нийгмийн халамжийн хөтөлбөрүүдээ цаашид үргэлжлүүлэх;
- 5 Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн цогц тогтолцоог бүрдүүлж, асаргааны даатгалын эрх зүйн орчин бий болгох, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх;
- 6 Ахмад настны хөдөлмөрийн харилцаан дахь оролцоог сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, боловсрол эзэмших эрхээ эдлэх бололцоогоор хангах;

Насжилтыг дэмжих, ахмад настны эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих, хүчирхийлэл болон бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцлийг бүрдүүлэх

Дөрөв. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаар Додлогын суурь тавигдсан ч түүнийг хэрэгжүүлэх механизмгүй байна.

22. Монгол улс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд бүрэн оролцох, тэдний өвөрмөц хэрэгцээнд нийцсэн нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдүүлэх зорилготой ХБХЭК-ийн үзэл агуулгад нийцсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд 2016 онд баталж түүнийг хэрэгжүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний

хөтөлбөр” баталсан нь сайшаалтай ч түүний хэрэгжилт маш удаан явцтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд 2016 хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох эрхтэйг (14.1) заагаад хөгжлийн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах тухай (14.3.1), мөн бүх шатны боловсролд тэгш хамруулахыг (14.3.2)-д заажээ. Эндээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургахыг Монгол улс өнөөдөр бодлогоо болгожээ гэж дүгнэж болно.

23. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг шийдвэрлэхэд ганцхан хуулийн ерөнхий заалт хангалтгүй. Хууль дагаж гарах олон журам гарсан тохиолдолд хууль хэрхэн хэрэгжих арга механизм нь тодорхой болох ёстой ч өнөөдрийг хүртэл хууль гарснаас хойш 4 жил болох гэж байхад 3 журам гарсан байна. Иймээс багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах талаар хэрхэн бэлтгэх, яаж урамшуулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хэрхэн хангах, ямар дэмжлэг үзүүлэх, яаж нөхөн сэргээх үйлчилгээтэй сургалтыг зохицуулах, багш нарын хандлагад нь тодорхойгүй байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамран сургах тогтолцоо бүрэлдэн тогтоогүй, зөвхөн эхлэл төдийхөн маш удаан явагдаж байна. Гэвч өнгөц харвал хууль батлагдсан, түүнийг хэрэгжүүлэх журам гарсан мэт санагдах бодит нөхцөл дээр ахиц удаан байна.
24. **Тэгш хамруулах боловсролын тогтолцоо муу ажиллаж байна.** Бага, дунд боловсролын тухай хуульд Ерөнхий боловсролын тусгай сургууль гэсэн бүлэг байгаа нь тэгш хамруулах боловсролын тогтолцоонд шилжих энэ үед эцэг эх, асран хамгаалагч нарт ямар сургуульд хүүхдээ өгөх сонголт хийх боломж өгөх төдийгүй сургууль хооронд харилцан шилжих нөхцөлөөр хангаж байна.
25. Монгол Улсын Их хурлын 2017 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 46 дугаар тогтоол нь тэгш хамрах боловсролын хэд хэдэн чухал асуудлын шийдлийг олох, хийлгэх үүрэг өгсөн ч тусгай сургууль, насан туршийн боловсролын үндэсний төв гэсэн нэлээн хэдэн заалт орсон нь хэвшмэл ойлголт хандлагаасаа салж чадаагүй үед тэгш хамрах боловсролын заалтуудын хэрэгжилтийг хангах асуудлыг зохион байгуулахын оронд тусгай сургууль, насан туршийн боловсролтой холбоотой асуудлуудад хүч, хөрөнгөө зарцуулж байна. Засгийн Газрын 2017 оны 162 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/195, А/196 тушаал гарсан нь бүгд тусгай сургуулийн ажил, үйлчилгээтэй холбоотой байна. Тусгай 6 сургуульд тавилга, тоног төхөөрөмж, автобус 2018

оны боловсролын салбарын төсвөөс 2.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Хамгийн харамсалтай нь хөдөө орон нутгуудад ердийн сургуульд тусгай анги нэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бөөгнөрүүлэн сургах практик дэлгэрэх хандлагатай болж байна. Иймээс тэгш хамрах боловсрол бус, харин тусгай сургуулийн нүүрээ хувиргасан тусгай анги, насан туршийн сургалтууд хөгжих чигт явж эхэллээ. Өмнөх зөвлөмжөөр өгсөн тэгш хамруулах боловсрол удаан ахицтай байна.

26. **Санхүүжилтийн хувиарлалт оновчгүй, бодлогод уялдахгүй байна.** 2018 онд тусгай хэрэгцээт боловсролд 7,5 гаруй тэр бум төгрөг, насан туршийн боловсролд 5,3 тэр бум төгрөг 2018 оны төсвийн хуваарьт^{xxxiii} тусжээ. 2019 оны төсөвт тусгай боловсролд 4,2 тэр бум гаруй, насан туршийн боловсролд 4,1 тэр бум гаруй төгрөг зарцуулахаар^{xxxiv} төлөвлөжээ. Энэ хоёр оны улсын төсвөөс харахад тэгш хамруулах боловсролд мөнгө зарцуулаагүй, зарцуулахааргүй байна. Эндээс мөн тэгш хамрах боловсролыг хөгжүүлэх талаар хойрог байгаа нь харагдана.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах үйлчилгээний хувийн туслах үйлчилгээний нэг цагийн ажлын хөлсийг 3500 ₮(\$1.31) –өөр тогтоосон нь хувийн туслах ажилтны 2 автобус дамжин үйлчлүүлэгч дээр ирж очих унааны зардалд үндсэндээ зарцуулагдахаар байна. Иймээс хувийн туслахын ажил хийх хүн олдохгүй болох магадлал маш өндөр. Энэ хоёр жишээтэй адил хөгжлийн бэрхшээлтэй хүнд шууд очих үйлчилгээн дээр санхүүжилт гаргахгүй хойрог хандаж буйг өөрчлөх шаардлага байна.

Зөвхөн энэ хоёр төдийгүй барилга байгууламж, зам, нийтийн тээврийн хүртээмж зэрэг асуудалд санхүүжилт тун бага гаргаж байна.

27. **Ялгаварлан гадуурхах явдал ялангуяа боловсролын салбарт байсаар байна.** Багш нарын хүний эрхийн ойлголт хангалтгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн ангид сурахад багш тусгай сургууль руу явуулж болохгүй гэсэн хуулийн заалтын дагуу шууд хүүхдийг сургахгүй гэж хэлэхгүй ч тухайн хүүхдийг тусгай сургууль руу явуулах талаар янз бүрийн ятгах, шахах арга хэмжээ авч байна. Багш нар, сургуулийн удирдлагын энэхүү хандлагыг өөрчлөхийн тулд багш нарын мэргэжлээ дээшлүүлэх тогтолцооны бүх хэлбэрт, олон төвшинтэй хүний эрх, тэгш хамрах боловсролын сургалтын нарийн боловсруулсан хөтөлбөр нэвтрүүлэх шаардлагатай байна.

28. **Тохирох хэрэглэгдэхүүн хэрэглэгдэхгүй байна.** Тохирох хэрэглэгдэхүүнийг боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг салбарт нэвтрүүлэх эрх үүссэн. Сургуулийн удирдлага, багш нар нь өмнө дурдсан хүний эрхийн болоод Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын талаар хангалтгүй мэдлэгтэй учир өөрсдөө хүүхдийг ялгаварлан

гадуурхаж байгаага ч ухаарахгүй тохиолдол олон байна. Жишээлбэл “манай сургуулийн орчин чамд тохирохгүй учир чи тусгай сургуульд сурсан нь сайн” гэж хэлж байгаа сургуулийн удирдлага, багш олон тохиолдолд таарсан, ямар нэг эмээсэн зүйлгүй, харин ч их зөв зөвлөгөө өгч байна гэсэн хандлага гаргаж буй нь хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах тухай мэдлэг хангалтгүйн жишээ. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт ч тохирох хэрэглэгдэхүүнтэй ажлын байрыг дэмжих тухай яригдах ч яаж дэмжих нь тодорхойгүй байна.

29. Тохирох хэрэглэгдэхүүний талаар ойлголт мэдлэгээ нэгтгэх, түгээх ажлыг хийх шаардлага үүссэн нь өмнөх жишээнүүдээс тодорхой болж хүртээмж, тохирох хэрэглэгдэхүүн, дэмжлэг гэсэн ойлголт нь хоорондоо холилдсон, алийг нь хаана хэрэглэх нь тодорхойгүй байгаа. Иймээс тохирох хэрэглэгдэхүүн, хүртээмж, дэмжлэгийг хэзээ, хаана, яаж үзүүлэхийг тодорхой болгон үүрэг хариуцлагыг зааж өгөөгүй тохиолдолд ялгаварлан гадуурхалт орших нь тодорхой байгаа тул тохирох хэрэглэгдэхүүн, ялгаварлан гадуурхахын эсрэг төрийн зохицуулалт үгүйлэгдэжтухай мэдлэг хангалтгүйн жишээ юм.

30. **Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрх хангагдаагүй байна.** 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд Бие даан амьдрах эрхийг баталгаажуулж өгөн хэрэгжих болсон ч өнөөдрийг хүртэл эхлээгүй байна. Өмнө дурдсан хувийн туслахын ажлын нэг цагийн хөлс хийх хүн олдохгүй болох магадлал маш өндөр. Иймээс үр ашигтай үйлчилгээ болно гэх найдлага бага байна. Бие даан амьдрах үйлчилгээг эхлэх, тэр тусмаа хувийн туслахын цагийн хөлсийг бодитой тогтоон ажлыг үр өгөөжтэй явагдах боломжоор хангах шаардлага үүслээ. Хууль гарсан, журам боловсруулагдаж байна гэсэн хариугаар аливаа ажил, тайланг хаах бус, зохих хууль, журамдаа шаардлагатай өөрчлөлтөө оруулан хуульд туссан ажлыг хурдан эхлүүлэх шаардлага байна.

31. **Цаашид авах арга хэмжээ**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэн бодит амьдралтай холбох, үр өгөөжийг нь мэдрэх нөхцөлийг бүрдүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд оролцох бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн тэгш хамрах боловсрол, бие даан амьдрах эрх, хүртээмж, хөдөлмөрт эрхлэлтийг нэмэгдүүлэх аливаа үйл ажиллагааны санхүүжилт, төсвийн хэмжээг тогтмол нэмэгдүүлэх
- Тэгш хамрах боловсролын тогтолцоог бүрдүүлэхийн тулд хуулийн хэрэгжилттэй холбоотой болон амьдралаас урган гарах асуудлуудыг тэгш хамруулах үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлэх.

- Монгол улсад шинээр нэвтэрч буй хөгжлийн бэрхшээлтэй холбоотой нэр томъёо, ойлголтыг олон улсын жишгийн дагуу авч хэрэгжүүлэх, ашиглах,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэх хувийн туслах үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэн тэдний эрх ашигт нийцүүлэн, үр дүнтэй, хүрэлцэхүйц төсөвтэй хэрэгжүүлж эхлэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үл тоомсорлох, ялгаварлан гадуурхах уламжлалт хандлагыг өөрчлөх зорилгоор тодорхой бодлого, төлөвлөгөө, төсөвтэй үйл ажиллагааг зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй залуусыг хөдөлмөрт бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, хөдөлмөрийн нээлттэй зах зээлд өрсөлдөх чадвартай болгоход чиглэсэн тогтвортой, системтэй ажил хийх
- Багш бэлтгэх ба мэргэжил дээшлүүлэх тогтолцооны хөтөлбөрт хүний эрхийн сургалтын нэмж оруулан заавал үзэх хилээл болгох

ⁱ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13.1.3.

ⁱⁱ СХТБ-ын нийгэмшүүлэх үйлчилгээний үнэлгээний тайлан, 13х, 2018, УБ

ⁱⁱⁱ ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019 оны 4 сарын мэдээлэл

^{iv} Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолын хавсралт

^v Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолын хавсралт

^{vi} Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолын хавсралт

^{vii} 108.41, 108.42, 108.44, 108.139, 108.140, 108.141, 108.142, 108.143, 108.144, 108.145, 108.158

^{viii} “АББД-ын эсрэг авах арга хэмжээний талаарх олон нийтийн хандлага” онлайн судалгаа, тоон болон чанарын судалгаа АББД-ий тэмцэх Эвсэл, 2016 он

^{ix} “Охид эмэгтэйчүүдийн ажлын байран дахь бэлгийн дарамтын төлөв байдал, хандлага” харьцуулсан судалгаа (2004, 2017 он) МОНЭС ТББ

^x ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, цалин орлогын улирлын мэдээ www.1212.mn

^{xi} Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал А/177, 2018.06.28

^{xii} Эх сурвалж: ҮСХороо, Ажиллах хүчний судалгаа

^{xiii} Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, хуудас 22

^{xiv} Хүн амтын тоо, ҮСХороо

^{xv} Боловсролын статистик 2018 он, БСШУЯ

^{xvi} ХНХЯ-аас ирсэн тайлбарт

^{xvii} Эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо

^{xviii} Цаг ашиглалтын судалгаа, 201 он, 2015 он, Үндэсний статистикийн хороо

^{xix} “Хөдөлмөрийн нөхцөл байдал” асуулга судалгааны тайлан МЭХДХ, 2019 он

^{xx} МЭХДХ-оос 2019 оны 6 сард Улаанбаатар хотын задгай зах дээр ажилладаг 100 эмэгтэйн хүрээнд хийгдсэн асуулгын дүгнэлтээс

^{xxi} *Иргэний сонгох, сонгогдох эрхийн талаар УИХ-ын болон Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд (6.1) “сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй” хэмээн заажээ. Харин Улс төрийн намын тухай хуулийн 5.1.3-д гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход хүйсээр ялгаварлахгүй адил тэгш боломж олгохыг намууд үйл ажиллагааныхаа зарчим болгохыг зааж өгчээ.*

^{xxii} Тухайн үед эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагууд санаачлан нийт 277 байгууллагын төлөөлөлтэйгээр эсэргүүцэл илэрхийлж, шаардах бичиг хүргэж байв.

<http://www.hiub.mn/content/read/8347.htm>

^{xxiii} **10 дугаар зүйл.Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа, ЖЭТБХТХууль**

^{xxiv} “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь”.2014 он. УБ. “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд НҮБХХ, ЖҮХ хамтран боловсруулсан гарын авлага

^{xxv} Улс төрийн санхүүжилт гэсэн нэр томъёогоор улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн санхүүжилт гэсэн 2 ойлголтыг хамтад нь авч үзсэн болно.

^{xxvi} НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд ИНБ-гаас илгээсэн UPR-III циклийн дунд шатны тайлангаас

^{xxvii} www.Legalinfo.mn / Ахмад настны тухай хууль/ 2017 он

^{xxviii} www.1212.mn

^{xxx} Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа, Үндэсний Статистикийн хороо, 2018 он

^{xxxi} Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөгөө өгөх НҮБ, АХБ-ны хамтарсан ажлын хэсгийн тайлан

^{xxxi} Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, УИХ, 2016.09.09

^{xxxi} https://mof.gov.mn/files/uploads/article/Tusviin_huvaari.pdf

^{xxxi} https://mof.gov.mn/files/uploads/article/20181217_book_MON_final_1.pdf